



**“АЛТАН ШАНАГА” ХХК**

**Байгаль орчны аудит, байгаль орчны менежментийн  
зөвлөх үйлчилгээ**



**“БАДРАХ ЭНЕРЖИ” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
УЛААНБАДРАХ СУМЫН НУТАГТ ОРШИХ УРАНЫ ОРДЫГ  
(MV-018914, MV-018915, MV-018916) УУСГАХ АРГААР  
ОЛБОРЛОН БОЛОВСРУУЛАХ ТУРШИЛТЫН  
ҮЙЛДВЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ  
АУДИТЫН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2023 он



**“БАДРАХ ЭНЕРЖИ” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
УЛААНБАДРАХ СУМЫН НУТАГТ ОРШИХ УРАНЫ ОРДЫГ  
(MV-018914, MV-018915, MV-018916) УУСГАХ АРГААР ОЛБОРЛОН  
БОЛОВСРУУЛАХ ТУРШИЛТЫН ҮЙЛДВЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТЫН ТАЙЛАН**

**АУДИТ ХИЙСЭН МЭРТЭЖЛИЙН  
БАЙГУУЛЛАГА:**

**“АЛТАН ШАНГА” ХХК-ИЙН,  
БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ АУДИТОР**



**/Д.ГАНТӨМӨР/**

Улаанбаатар хот  
2023 оны VI сар

## Агуулга

### Тайланг бэлтгэсэн:

Байгаль орчны аудитын  
“Алтан шанага” ХХК-ийн  
аудитын баг

### Багийн ахлагч, ахлах аудитор:

Д.Гантөмөр

### Туслах аудитор:

О.Батгэрэл  
Н.Аззаяа

### Гэрээт зөвлөх:

Ц.Нямсүрэн

### Аудит хийсэн хугацаа: 2023 оны VI сар

### Хүчинтэй хугацаа: 2025 оны VI сар

Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 99102135 дугаарын утсаар харилцана уу.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	2
ОРШИЛ .....	3
АУДИТЫН ЗОРИЛГО .....	4
АУДИТ ХИЙЛГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
НЭГ. ХУУЛИЙН ЕРӨНХИЙ НИЙЦЛИЙН АУДИТ .....	12
ХОЁР. УСНЫ НӨӨЦ АШИГЛАЛТ, УСНЫ ЧАНАР БОХИРДОЛ .....	24
ГУРАВ. ХӨРСӨН БҮРХЭВЧ БА ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ ..	34
ДӨРӨВ. БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ, УРГАМЛАН НӨМРӨГ БА БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ .....	39
ТАВ. АГААРЫН ЧАНАР, ФИЗИК НӨЛӨӨЛӨЛ .....	43
ЗУРГАА. ХИМИЙН ХОРТ БОДИС, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ .	48
ДОЛОО. ТЕХНОЛОГИ, ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА .....	65
БО-НЫ АУДИТЫН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭЛ, ГҮЙЦЭТГЭЛ .....	68
БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	69
АУДИТЫН ДҮГНЭЛТИЙГ ТАРААХ.....	70
БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ .....	70
АУДИТААР ИЛЭРСЭН ҮЛ НИЙЦЛИЙГ ЗАЛРУУЛАХ ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ .....	71
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ .....	72

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АМГ	Ашигт малтмалын газар
АХХ	Ахуйн хог хаягдал
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
АМХЭГ	Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар
АТХ	Агаарын тухай хууль
АБТТХ	Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хууль
АмТХ	Амьтны тухай хууль
БО	Байгаль орчин
БОА	Байгаль орчны аудит
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОХТ	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБҮТ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
БОЯБДХ	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах
БХХ	Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч
БНАТТХ	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
БНС	Биологийн нөхөн сэргээлт
ГХТХ	Газрын хэвлийн тухай хууль
ДХТ	Дүйцүүлэн хамгалах төлөвлөгөө
ДЦҮ	Дизель цахилгаан үүсгүүр
ЗД	Засаг дарга
ЗГ	Засгийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЖБОМТ	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ТНС	Техникийн нөхөн сэргээлт
ТХ	Төсөл хэрэгжүүлэгч
ТХХ	Техникийн хог хаягдал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СГЗ	Сав газрын захиргаа
ОХШХ	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
ЦБ	Цэвэрлэх байгууламж
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
УЦУОШГ	Ус цаг уур орчны шинжилгээний газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УБД	Улсын бүртгэлийн дугаар
РД	Регистрийн дугаар
ЭБЗ	Эрдэс баялгийн зөвлөл

## ОРШИЛ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу “Алтан шанага” ХХК-ийн аудитын баг байгаль орчны аудитыг “Бадрах энерги” ХХК-ийн Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших ураны ордыг (MV-018914, MV-018915, MV-018916) уусгах аргаар олборлон боловсруулах туршилтын үйлдвэрийн үйл ажиллагаанд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг хийж гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөт аудитаар “Бадрах энерги” ХХК-нд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйл ажиллагаа явуулахад туслах, тэднийг учирч болох алдагдал, хохирлоос сэргийлэх үүднээс байгаль орчны төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, хууль тогтоомж, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, аудит хийлгэгч байгууллага, холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Байгаль орчны аудитыг гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнд “Алтан шанага” ХХК-ийн захирал ахлах аудитор, багийн ахлагч Д.Гантөмөр, туслах аудитор О.Батгэрэл, Н.Азжая, гэрээт зөвлөх Ц.Нямсүрэн нар оролцлоо.

Байгаль орчны аудитыг газар дээр гүйцэтгэхэд аудит хийлгэгч байгууллагаас уурхайн байгаль орчны ажилтан Мэргэжилтэн О.Батмягмар, Ахлах химич Ж.Нацагмаа, Менежер Н.Нансалмаа байлцлаа.

## АУДИТЫН ЗОРИЛГО

“Бадрах энерги” ХХК-ний туршилтын үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар ашиглалт явуулахад туслах, тэднийг учирч болох алдагдал, хохирлоос сэргийлэх үүднээс байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго оршино. Байгаль орчны хуваарьт аудитыг дараахь чиглэлүүдээр гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хуулийн ерөнхий нийцэл
2. Усны нөөц ашиглалт, усны чанар, бохирдол
3. Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлт
4. Ургамлан нөмрөг, биологийн олон янз байдал ба биологийн нөхөн сэргээлт
5. Агаарын чанар, физик нөлөөлөл
6. Хог хаягдал, химийн бодисын менежментийн аудит
7. Технологи, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа тус тус хамаарна.

## АУДИТ ХИЙЛГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1. Төслийн ерөнхий мэдээлэл

#### Төслийн нэр

“Зөөвч Овоо” ураны ордыг олборлох туршилтын үйлдвэрийн төсөл

#### Төслийн зорилго



Тус ордыг Байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар олборлож, тухайн бүс нутагт ажилгүйдлийг багасгаж, ажлын байр нэмэгдэхээс гадна улс орны төсөвт татвар төлөөс өгч орон нутгийн нийгэм эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулах

#### Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын нэр

“Бадрах энерги” ХХК, улсын бүртгэлийн дугаар: 9011302095, регистрийн дугаар: 5502977, Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн дугаар: MV-018914, MV-018915, MV-018916

#### Төслийн байршил

Зөөвч Овоо орд нь Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн урагш 460 км, Сайншанд хотоос баруун урагш 70 км, Улаанбадрах сумаас баруун хойш 48 км-т байрлана.



Зураг 0.1 “Зөөвч Овоо” ордын байршил

Бадрах энерги ХХК-ийг анх 2011 онд “Аревамайнс” ХХК нэртэйгээр “Гадаад худалдаа”-ны үндсэн үйл ажиллагааны чиглэлийг бүртгэж улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон. 2016 онд “Ньюкоже” ХХК-ийг нэгтгэж, 2018 онд оноосон нэрийг “Бадрах энерги” ХХК болгон бүртгэсэн.

## 2. Туршилтын үйлдвэрийн технологи үйл ажиллагааны товч мэдээлэл

### АМАТЗ-ийн мэдээлэл



Бадрах энерги ХХК нь хил залгаа орших MV-018914, MV-018915, MV-018916 дугаар бүхий 3 хэсэг АМАТЗ-ийг эзэмшдэг. Анх 2015 онд Кожеговь ХХК-д эдгээр тусга зөвшөөрлүүд олгогдсон ба 2016 онд Аревамайнс ХХК-д шилжсэн. MV-018916 Дулаан уул талбайн 4317.19 га хэсгийг 2018 онд буцаан өгөх үед солбицолд 1 удаа өөрчлөлт орсон. MV-018915 Зөөвч Овоо, MV-018914 Өмнөт талбайн анх олгосон солбицолд өөрчлөлт ороогүй байна.

Ашигт малтмалын MV-018914, MV-018915, MV-018916 болон ТЗ-ийн талбайн 2023 оны байдлаар бүртгэлтэй байгаа солбицлуудыг хавсаргав.

### *Товч танилцуулга*

“Бадрах энерги” ХХК-ий MV-018914, MV-018915, MV-018916 ТЗ-тэй талбайн ашиглалтыг анхны ТЗ эзэмшигч ашиглаж эхэлсэн хугацаанаас хойш кемпийн ашиглалтын зориулалтаар 12.93 га (Зөөвч Овоо кемп 7.35 га, Дулаан уул кемп 3.88 га, Өмнөт талбай дахь өрмийн кемп 1.7 га), туршилтын хоёр үйлдвэрийн зориулалтаар 2.15 га (Зөөвч Овоо туршилтын үйлдвэр 1.36 га, Өмнөтийн туршилтын үйлдвэр 0.79 га), шаврын сангийн (3.22 га) зориулалтаар газар ашигладаг. Өмнөтийн туршилтын үйлдвэрийг (ISR) 2010 онд ашиглаж байгаад зогсоосон. Зөөвч Овоо туршилтын үйлдвэрийн (ISR) үйл ажиллагааг жигдрүүлж цаашид олборлолт явуулахаар зорьж байгаа.

### *Ус хангамж*

Үйлдвэрлэл ба ахуйн хэрэгцээний усыг өрөмдмөл худгуудаас авч хэрэглэдэг. Үйлдвэрлэлийн хэрэгцээнд 7 гүний худаг өрөмдөн гаргасан.

### *Технологи*

Зөөвч Овоо ордын ГДУО (газрын доорхи уусган олборлолт) олборлолтыг эхлүүлэх уусгагч уусмалыг гаргаж авахдаа хүдэртэй давхаргын газрын доорх усыг шахуургадаж гаргаад дээр нь хүхрийн хүчил нэмж, 2-15 гр/литр найрлага бүхий хүчилжүүлсэн уусмалыг зургаан өнцөгт торлолын өнцөг болгонд байрлах шахалтын цооногуудаар газрын гүнд дэх ураны хүдэр руу буцаан шахна. Хүчилжүүлсэн уусмал цооногийн шүүрэн хэсгээр дамжин эрдэсжсэн элсэнд нэвчин газрын гүн дэх ураны хүдрийг аажмаар уусгадаг. Хүхрийн хүчил нь газрын доорх усны рН-ийг бууруулах ба рН зохих түвшиндээ (рН=1.5) хүрмэгц исэлдүүлэгч агуулсан шингэнийг шахан ураны уусах орчныг нэмэгдүүлнэ. Уранаар баяжсан уусмалыг торлолын төвд байрлах олборлолтын цооногоор насосын тусламжтайгаар соруулна. Энэхүү уранаар баяжсан уусмалыг шингээлтийн хэсэгт дамжуулна. Уусмал дахь уран нь шингээлтийн багана/торх дахь ион солилцооны давирхайд бэхжиж үлдэнэ. Шингээлтийн хэсгээс урангүй болсон уусмалыг цооногийн талбай уруу буцаан шахна. Энэ үед хүчил дозлогчоос тохируулсан тунгаар хүчил урангүй уусмалд нэмэгдэн холилдож шахах цооногуудаар дамжин,



дахин эрдэсжсэн бүсээс ураныг уусгаад, олборлолтын цооногоор сорогдон шингээлтийн баганад /торхонд/ уранаа алдаад буцаж шахалтын хэсэгт дахин хуваарилагдана. Ингэж энэ олон үе шаттай процесс давтагдан битүү эргэлттэй явагдана. Хүдэр олборлох шатанд шингээлтийн багана (торхон) дахь давирхай уранаар бүрэн ханахад, урантай давирхайг боловсруулах хэсэгт дамжуулна. Зөөвч Овоо ордын хүдэр агуулагч уст давхарга их хэмжээний хлорид агуулдаг учир ураныг давирхайнаас NaCl ашиглан салгана. Ийнхүү эргэлдэх үйлдвэрлэлийн усны тодорхой хэсэг буюу тунадасжлуулалтын илүүдэл усыг шингэн хуримтлуулах санд байршуулах ба буцааж торлолын шингээлтийн хэсэг уруу шахна. Давирхайнаас салгаж авсан ураны баян уусмалыг аммонийн гидроксидоор  $\text{NH}_4\text{OH}$  саармагжуулж, шүүж шахан аммоний диурат /чийгтэй шар нунтаг/ гарган авна.

#### *Хаягдлын сан*


Туршилтын үйлдвэрийн хэсэг эргэлтийн усан сангийн байгууламжтай. Уг байгууламж нь үйлдвэрээс гарсан хаягдал усыг хураах нөөц усан сангийн зориулалттай. Одоогоор лабораторийн багаж тоног төхөөрөмжийн цэвэрлэгээнээс гарсан усыг уг сан руу шилжүүлж хадгалж байна. Үйлдвэрийн үйл ажиллагаа жигдрэх үед ажилчдын хувцас хэрэглэлийн угаалга цэвэрлэгээнээс үүсэх усыг хуримтлуулахаар төлөвлөж байгаа.

Дулаан уул болон Зөөвч Овоо кемпүүдийн хувьд ахуйн хэрэглээний бохир усыг цэвэршүүлэх байгууламжаар цэвэрлэж хөрсөнд нэвчүүлэх ба тээвэрлэлт хийх байдлаар төлөвлөлт хийгдсэн.

Аудит хийх хугацаанд буюу өнөөгийн байдлаар туршилтын үйлдвэрийн үйл ажиллагааг цаашид жигдрүүлэн байнгын олборлох шат руу шилжүүлж эхлээгүй байна.

#### *Химийн бодисын агуулах*

Олборлох зорилгоор тэсэлгээний ажил эрхэлдэггүй. Олборлолтод ашиглах химийн үндсэн 6 төрлийн бодис урвалжийг хадгалах агуулахуудыг Зөөвч Овоо туршилтын үйлдвэрийн хэсэгт байрлуулсан.



Зураг 0.1. Зөвч Овоо ордын газар ашиглалтын байдал

## **АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

“Бадрах энерги” ХХК-ийн Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших “Дулаан Уул”, “Зөөвч Овоо” ураны ордыг (ТЭЗҮ болон нөөцийн протоколд дурдсан нэршил) ордыг ашиглах төсөлд байгаль орчны аудитыг гүйцэтгэхдээ ашиглалтын 4366.04 га газрыг хамрах ТЗ бүхий талбайн олборлолтын холбогдол бүхий үйл ажиллагаагаар ашиглалтад өртсөн 20.0 га талбай дахь үйл ажиллагааны хувьд байгаль орчны хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, гүйцэтгэл, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлан, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, ашиглалтын үйл ажиллагааны тайлан, зөвшөөрөл, дүгнэлт, эрхийн актууд, гэрээ, хэлцлүүд, төлбөрийн баримт, материалыг хамруулан үзлээ. Байгаль орчны аудит нь хугацааны хувьд 2021-2022 оны хугацаанд явагдсан үйл ажиллагааг хамарна. Тус уурхайд байгаль орчны аудитыг 2021 оны 04 дүгээр сард гүйцэтгэсэн ба аудит гүйцэтгэж буй хугацаанд үл явагдаж байсан уурхайн үйл ажиллагааны гүйцэтгэлээр болон БОННУ-ний тайланд үл хамрагдсан үйл ажиллагаа (ТЭЗҮ, БОННУ-д дурдагдаагүй дурын үйл ажиллагаа), БОННУ-д тусгагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа үйл ажиллагаагаар тус аудит хамрах хүрээний хувьд хязгаарлагдана. Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд авч хэрэгжүүлсэн ажлын тайлангаа Дорноговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.

## **АУДИТЫН АРГАЗҮЙ**

Байгаль орчны аудитыг гүйцэтгэхдээ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/809 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал”-ыг удирдлага болгон ашигласнаас гадна гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, үйл ажиллагааны тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглалаа.

## **АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Аудитын зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах баримт бичгүүдийг ерөнхий шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

1. Агаарын бохирдлын төлбөрийн тухай
2. Агаарын тухай /шинэчилсэн найруулга/
3. Амьтны тухай / шинэчилсэн найруулга/

4. Ашигт малтмалын тухай
5. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай /шинэчилсэн найруулга/
6. Газрын тухай хууль
7. Ургамал хамгааллын тухай
8. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай /шинэчилсэн найруулга/
9. Байгаль орчныг хамгаалах тухай
10. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
11. Газрын төлбөрийн тухай
12. Газрын тухай /шинэчилсэн найруулга/
13. Газрын хэвлийн тухай
14. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
15. Ургамал хамгааллын тухай
16. Усны тухай /шинэчилсэн найруулга/
17. Ус бохирдуулсны төлбөрийн тухай
18. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
19. Химийн хорт болон аюултай бодисын тухай
20. Хог хаягдлын тухай
21. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
22. Хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, норм, норматив, эрхийн актууд, зөвшөөрөл, гэрээ, дүгнэлт
23. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан
24. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, биелэлтийн тайлан
25. Хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, норм, норматив, эрхийн актууд, зөвшөөрөл, гэрээ, дүгнэлт зэрэг болно.

### **Аудитыг гүйцэтгэсэн хугацаа**

Байгаль орчны аудитыг төлөвлөсний дагуу хийж гүйцэтгэсэн.

Үүнд:

I үе шат – Аудитын төлөвлөлт буюу бэлтгэл ажил: 2023.04.10 - 2023.06.10 хүртэл;

1. Аудитын зорилго ба хамрах хүрээг тодорхойлох
2. Аудитын шалгууруудыг олж тогтоох
3. Аудитын асуулга авах чиглэлийг тодорхойлох
4. Аудитын дэлгэрэнгүй төлөвлөгөө, хөтөлбөрийг бэлтгэх

II үе шат – Аудитын хэрэгжилт буюу хээрийн судалгааны ажил 2023.06.10 - 2023.06.12 хүртэл;

1. Аудитын нотлох зүйл олж авах



2. Аудитын нотлох зүйлийг баримтжуулах
3. Аудитын нотлох зүйлд дүн шинжилгээ хийх
4. Аудитын дүгнэлт гаргахад бэлтгэх

III үе шат – Аудитын тайлан боловсруулах - 2023.6.12 -2022.06.30 хүртэл;

1. Аудитын урьдчилсан дүгнэлтийг гаргах
2. Захиалагч, үйлчлүүлэгчийн удирдлагатай санал солилцох
3. Аудитын тайлангийн эцсийн хувилбарыг бэлтгэх
4. Аудитын бэлэн болсон эцсийн тайланг бусдад тараах
5. Аудитын тайланг танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг болно.

## Нэг. Хуулийн ерөнхий нийцлийн аудит

### Дэд зорилт:

Байгаль орчны салбарын ерөнхий хууль тогтоомжийн шаардлага, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг гүйцэтгэл, зөвшөөрлийг шалгаж, дүгнэлт өгөхдөө Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг удирдлага хэрхэн биелүүлж ажиллаж байгааг шалгах үндсэн зорилготой.

### Аудитын үр дүн

#### Хүснэгт 1.1. Хуулийн ерөнхий нийцлийн аудитын шинжилгээ

№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>1</sup>	Тайлбар
				Нийцэл	Үл нийцэл		
A.1.	Ашигт малтмалын тухай хуулийн 27-р зүйлийн 1 дүгээр хэсэг “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ” хэсгийн 1 дэх заалтад заасан “Тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа ашигт малтмалыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах”	Бадрах энерги ХХК нь хил залгаа орших MV-018914, MV-018915, MV-018916 дугаар бүхий 3 хэсэг АМАТЗ-ийг эзэмшдэг. Анх 2015 онд Кожеговь ХХК-д эдгээр тусга зөвшөөрлүүд олгогдсон ба 2016 онд Аревамайнс ХХК-д шилжсэн. MV-018916 Дулаан уул талбайн 4317.19 га хэсгийг 2018 онд буцаан өгөх үед солбицолд 1 удаа өөрчлөлт орсон. MV-018915 Зөөвч	-	5	-	5	

<sup>1</sup> Хяналтын эрэмбэд 1-10 хүртэл оноог оноох ба цар хүрээ багатай арга хэмжээнүүдэд 5 хүртэл оноонуудыг онооно. Арга хэмжээнүүдийн биелэлтийн хувиар нийцэл, үл нийцлийн оноог өгөх ба нэгж тутамд 20%-ийн биелэлт оноогдоно.

№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>1</sup>	Тайлбар
				Нийцэл	Үл нийцэл		
		Овоо, MV-018914 Өмнөт талбайн анх олгосон солбицолд өөрчлөлт ороогүй байна. [1]					
A.2.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 5 дугаар хэсэг “Шинээр байгуулсан хуулийн этгээдийг бүртгэх”, “Улсын бүртгэлийн байгууллага нь хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэснийг нотолсон хуулийн этгээдийн хувийн хэргийн болон регистрийн дугаар бүхий улсын бүртгэлийн цахим гэрчилгээг өргөдөл гаргагч хэвлэн авах боломжтойгоор улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд байршуулна”	Бадрах энерги ХХК-ийг анх 2011 онд “Аревамайнс” ХХК нэртэйгээр “Гадаад худалдаа”-ны үндсэн үйл ажиллагааны чиглэлийг бүртгэж 5502977 РД, 9011302095 дугаарт улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон. 2016 онд “Ньюкоже” ХХК-ийг нэгтгэж, 2018 онд оноосон нэрийг “Бадрах энерги” ХХК болгон бүртгэсэн. [18]	-	5	-	5	
A.3.	Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг “Сумын Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” 3 дахь заалт “... тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах”	Туршилтын үйлдвэрийн үйл ажиллагааг явуулах зорилгоор нийт 4366.04 га газарт уурхайн газрын зориулалтаар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Засаг даргын 2022 оны 02 сарын 08-ний А/12 дугаар шийдвэрийг үндэслэн “Газар ашиглах эрхийн гэрчилгээ”-г 2022 онд “Бадрах энерги” ХХК-ид олгосон. [4]	Газар ашиглуулах эрх олгосон гэрчилгээний хавсралт кадастрын зургийн мэдээллийн дагуу шинжилж үзэхэд Зөвч Овоо кемп, Дулаан Уул кемп болон өрмийн кемпийн зориулалтаар ашиглагдаж буй 13.0 орчим га газрууд бүхэлдээ, шаврын сангийн зориулалтаар ашиглагдаж буй газар хэсэгчилсэн байдлаар зөвшөөрөл олгосон газарт хамаарахгүй байна. Газар ашиглах	4	1	5	

№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>1</sup>	Тайлбар
				Нийцэл	Үл нийцэл		
			зөвшөөрөл олгогдсон хэсэг болон ашиглалт явуулж буй хэсгийн зургийг тайланд хавсаргав. (Хавсралт 1)				
A.4.	2020 оны Байгаль орчны аудитын тайлан зөвлөмж 2014-03-11 өдрийн тус сумын ЗД-н А37 тоот захирамжаар №000342841 дугаар бүхий 8 га газрыг хээрийн ангийн, мөн өдрийн №000342842 дугаартай 0,0225 га газрыг ахуйн хог хаягдлын зориулалтаар ашиглахаар зөвшөөрлийг сунгуулах	Шалгуур үзүүлэлтийн нийцлийг тогтоох боломжгүй		-	-	-	Аудитын хязгаарлалтад хамаарна

**Хүснэгт 1.1.1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний мэдээллүүд**

№	Гэрчилгээний дугаар	Зориулалт, байршил	Газрын хэмжээ	х.н.	Гэрчилгээ олгосон он	Хүчинтэй хугацаа	Нэгж талбар
1	*	Уурхайн газар	6175650	м <sup>2</sup>	2022	2027	4405002501
2	*	Уурхайн газар	1542396	м <sup>2</sup>	2022	2027	4405002411
3	*	-	699547	м <sup>2</sup>	2022	2027	4405002499
4	*	Уурхайн газар	35242900	м <sup>2</sup>	2022	2027	4405002500
<b>Нийт</b>			<b>43660493.0</b>				

\* - мэдээлэлгүй

A.5.	Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг "... газар эзэмшүүлэх тухай шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, сумын газрын алба	2022 онд гаргасан шийдвэрийн дагуу Газар ашиглах гэрээ байгуулах албан хүсэлтийг 2023 оны 05 сарын 18-ний өдөр гаргасан. [35]		5	-	5	
------	---	---	--	---	---	---	--



№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>1</sup>	Тайлбар
				Нийцэл	Үл нийцэл		
	тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ”	ГЗБГЗЗГ-ын мэдээллийн сангийн бүртгэлд “Бадрах энерги” ХХК-ид нийт дүнгээр 673,677,287.0 төгрөгийн төлбөрийг жил тутам ноогдуулсан. 2021-2022 оны хугацаанд байгуулсан газар ашиглах гэрээний дэлгэрэнгүй мэдээллүүдийг доорхи хүснэгтэд үзүүлэв:					
<b>Хүснэгт 1.1.2. Газар эзэмшүүлэх гэрээний мэдээллүүд</b>							
№	Гэрээний дугаар	Зориулалт, байршил	Газрын хэмжээ	х.н.	Он	Хүчинтэй хугацаа	Ноогдуулсан төлбөр, төг/жил
1	*	Уурхайн газар	6175650	м <sup>2</sup>	2022	Гэрчилгээний хүчинтэй хугацаагаар жил бүр дүгнэх	195,121,049₮
	*	-	1542396	м <sup>2</sup>	2022		61,918,440₮
	*	Уурхайн газар	699547	м <sup>2</sup>	2022		22,105,685₮
	*	Уурхайн газар	35242900	м <sup>2</sup>	2022		394,532,113₮
<b>Нийт</b>			<b>43660493.0</b>		-		<b>673,677,287.0</b>
* - мэдээлэлгүй							
А.6.	Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэг, “газрын төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх”, 35 дугаар зүйлийн “Газар эзэмшигч ... үүрэг хүлээнэ” 3.3 дугаар хэсэг “Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зохих хууль тогтоомж, гэрээний дагуу газрын төлбөр төлнө” Газрын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйл “Газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа ... газарт төлбөр ногдуулна”, 9 дүгээр зүйлийн 2 дугаар хэсэг “Газрын	04431-2022/00003, 04431-2022/00004, 04431-2022/00005, 04431-2022/00006 дугаарт Газрын төлбөрийн тооцоо нийлсэн актуудыг 2023 оны 05 сарын 02-ний өдөр авсан ба уг актын дүнгээр газрын төлбөрийн үлдэгдэлгүй байна. [5, 6]		5	-	5	

№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>1</sup>	Тайлбар
				Нийцэл	Үл нийцэл		
	төлбөр төлөгч нь газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд өөрөөр заагаагүй бол жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улирал бүрийн эхний сарын 25-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно”						
A.7.	Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйл. Газар эзэмшүүлэхэд тавигдах шаардлага: 4 дэх хэсэг “... ашигт малтмалын хайгуул хийх, ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан”	Ашиглалтын ТЗ-тэй талбайд явуулсан Археологийн хайгуул судалгааны ажлын тайлан, дүгнэлт”-ийн хувьтай аудитын явцад танилцах боломжгүй байв.		-	-	-	Үр дүнгийн үзүүлэлтэд үл хамаарна
A.8.	Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайланг ашигт малтмал эрэх, хайх үйл ажиллагааны журам, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалд нийцүүлэн боловсруулж, шинжээчийн дүгнэлт гаргуулан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө”	Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших дахь Зөөвч Овоогийн ураны ордод 2012-2018 онуудад гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланг АМГТГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гаргуулсан. Нөөц хүлээн авч бүртгэх тухай АМГТГ-ын даргын н/28 дугаар тушаалыг 2020 оны 04 сарын 15-ны өдөр гаргасан. [11]		5	-	5	
A.9.	Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийж, нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газраас олборлолт явуулж	“Улсын төсвөөс хайгуулын ажилд гаргасан зардлыг нөхөн төлөх тухай” ХАЗ 2017/01/37 дугаарт гэрээг 2017 онд байгуулж “Зардлыг нөхөн төлсөн		5	-	5	

№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>1</sup>	Тайлбар
				Нийцэл	Үл нийцэл		
	байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуулын ажилд улсын төсвөөс гаргасан зардлыг олборлолт явуулж эхэлсэн хугацаанаас эхлэн гэрээний үндсэн дээр улсын төсөвт буцааж нөхөн төлнө”	тухай акт”-ыг 2021 онд авсан. . [36]					
A.10.	Газрын хэвлийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашиглана”, 2 дахь хэсэг “Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллагын техник ашиглалтын журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр холбогдох төрийн захиргааны төв байгууллага батална”	Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Дулаан Уул, Зөөвч Овоогийн ураны ордуудыг газар доор уусган олборлох аргаар ашиглах, боловсруулах үйлдвэрийн Техник-эдийн засгийн үндэслэлийг “Кожеговь” ХХК-ийн захиалгаар 2014 онд “Гложекс” ХХК боловсруулж АМГТГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хянуулж батлуулсан. [17]		7	-	7	
A.11.	Ашигт малтмалын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 26.5-д заасны дагуу тусгай зөвшөөрлийн бүртгэлд бүртгүүлснээс хойш 3 сарын дотор мэргэжлийн хяналтын албаны тавьсан техникийн шаардлагын дагуу уурхайн талбайн хилийг тогтоолгож, байнгын шав тэмдэг тавих бөгөөд уурхайн талбайн хилийн хэмжилтийг төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан этгээдээр хийлгэж, хил тогтоосон тухай актыг тус албанд ирүүлнэ”	Өмнөт талбайн хувьд “Байгууллага аж ахуйн нэгжийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй талбайн хилийг тогтоож шав тэмдэг суулгасан ажлын тайлан”-г “Кожеговь” ХХК-ний захиалгаар 2015 онд “Жи ди эс эс” ХХК, Дулаан Уул, Зөөвч Овоо талбайн хувьд “Ашиглалтын талбайн хилийг тогтоож шав тэмдэг суулгасан ажлын тайлан”-г Бадрах Энержи ХХК-ийн захиалгаар Бейс пойнт ХХК 2018 онд тус тус гүйцэтгэсэн. [28]		2	-	2	

№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>1</sup>	Тайлбар
				Нийцэл	Үл нийцэл		
A.12.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дэх хэсэг “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан дотоодын аж ахуйн нэгж гүйцэтгэнэ” 39 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг “... ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө, сонгон шалгаруулалтын журмаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд уг зөвшөөрөл авсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах”	“Бадрах энерги” ХХК-ийн Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт байрлалтай “Зөөвч Овоо” ордын талбайд ураныг газар доор уусган олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн туршилт” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотголын тайланг 2021 онд “Экологийн бүтээмж” ХХК-иар гүйцэтгүүлсэн. [3]		5	-	5	
A.13.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална”	2021, 2022, 2023 оны тухайн жилийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ийг БОАЖЯ-ны ХБОБНУГ-аар батлуулж ажилласан. [14, 15]		5	-	5	
A.14.	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн	БОННУ-ний хүрээнд батлагдсан 2021,		1	-	1	



№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>1</sup>	Тайлбар	
				Нийцэл	Үл нийцэл			
	31 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг “Байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.7 дахь хэсэг	2022 онд батлагдсан ТЖБОМТ-нд байгаль хамгаалах арга хэмжээний жилийн зардлыг тодорхой зааж тусгасан. [14, 15] 2021-2023 оны хугацаанд байгаль орчныг хамгаалах талаар төлөвлөсөн болон зарцуулсан зардлын задаргааг хүснэгт 1.1.3-т үзүүлэв:						
<b>Хүснэгт 1.1.3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтэнд зарцуулсан зардал</b>								
№	Он	Байгаль орчныг хамгаалах зардал /сая төг/		ТНС, БНС /сая төг/		Нийт зардал /сая төг/		Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны хөрөнгө /сая төг/
		Төлөвлөсөн	Зарцуулсан	Төлөвлөсөн	Зарцуулсан	Төлөвлөсөн	Зарцуулсан	
1	2021	54.0	*	-	-	54.0	*	*
2	2022	62.0	*	-	-	62.0	*	*
3	2023	30.0	Биелэлтийг тайлагнах болоогүй	-	-	30.0	Биелэлтийг тайлагнах болоогүй	*
* - мэдээлэлгүй								
A.15.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1.2 дэх хэсэг “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах”	Төсөл хэрэгжүүлэгч нь 2021, 2022 оны ТЖБОМТ-ний биелэлтийн тайланг хянуулж ажилласан. [16]		5	-	5		

№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>1</sup>	Тайлбар
				Нийцэл	Үл нийцэл		
A.16.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 10 дугаар хэсэг “Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлэсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ”	ТЖБОМТ-ний байгаль хамгаалах ажлын арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулах төсвийн 50 хувийн барьцаа төлбөрт 2021 онд байршуулсан 27.0 сая төгрөг, 2022 онд 31.0 сая төгрөг, 2023 онд 15.0 сая төгрөг тус тус төлсөн. [12]		5	-	5	
A.17.	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “... дотоодын хяналтыг хэрэгжүүлэх”	Бадрах энерги ХХК-ий Захирлын “Дотоод хяналт шалгалтын ажилтан томилох тухай” тушаалаар дотоод хяналт шалгалт зохион байгуулах ажилтанг томилж Дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг жил бүр батлуулан ажиллаж байна. [10] Дотоод хяналт, шалгалт хийсэн ажлын тайлан, бүртгэлийг хөтөлж ажилласан		3	-	3	
A.18.	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулах бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход	Төслийн 3 хэсэг талбайн хувьд Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг (ГТБЧУХБ) 2021 онд “Мөнх байгаль энерги” ХХК-иар гүйцэтгүүлсэн. [7]		5	-	5	

№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>1</sup>	Тайлбар
				Нийцэл	Үл нийцэл		
	энэхүү баталгааг гаргана”						
A.19.	Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйл	Төслийн талбайд газар дээр нь байгаль орчны аудит хийхэд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар, ашигт малтмал ашиглах техник, эдийн засгийн үндэслэл болон зохих байгууллагаар хянуулсан ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, газар ашиглах тухай гэрээ, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө зэрэг бичиг баримтуудыг байлгаж байв.		1	-	1	
A.20.	Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэг “... мэдээ, тайлан гаргаж төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх” Газрын хэвлийн тухай хуулийн 32 дугаар зүйл “газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглахад тавих үндсэн шаардлага”	Туршилтын үйлдвэрийн үйл ажиллагааг явуулах зорилгоор 2021 онд “Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Зөөвч Овоо орд (Баяжуулах, боловсруулах үйлдвэр)-ийн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г АМГТГ-аар батлуулан ажилласан. [2]		5	-	5	
A.21.	Энэ нь ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана”	Төсөл хэрэгжүүлэгч нь нийгмийн хариуцлагын хүрээнд “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-г Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Засаг даргатай байгуулсан. [13]		5	-	5	

№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>1</sup>	Тайлбар
				Нийцэл	Үл нийцэл		
А.22.	Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйл. “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг”, 4 дэх хэсэг “Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисс уурхайг хүлээн авсны дараа ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг уурхайг ажиллуулж эхэлнэ”	Туршилтын үйлдвэрийн барилга угсралтын ажлыг 2018 онд дуусгаж “Бадрах энерги” ХХК-ий туршилтын түр зориулалтын ураны уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтанд хүлээн авах улсын комиссын актыг 2019 оны 7 сард авсан. [37]		5	-	5	
<b>Нийт оноо</b>				<b>88</b>	<b>1</b>	<b>89</b>	
<b>Гүйцэтгэлийн үр дүн /%/</b>				<b>98.9</b>	<b>1.1</b>	<b>100.0</b>	



## Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аудит хийлгэгч байгууллагад зөвлөж байна. Хүснэгт 1.2.

### Хүснэгт 1.2. Хуулийн ерөнхий үл нийцлийг залруулах арга хэмжээ

Үл нийцлийн дугаар	Залруулах арга хэмжээ
А.3.	Зөөвч Овоо кемп, Дулаан Уул кемп болон өрмийн кемпийн зориулалтаар ашиглагдаж буй 13.0 орчим га газар, шаврын сангийн газрыг бүрэн хэмжээгээр газар ашиглах зөвшөөрөлд хамруулах

## ХОЁР. УСНЫ НӨӨЦ АШИГЛАЛТ, УСНЫ ЧАНАР БОХИРДОЛ

### Дэд зорилт:

Төслийн үйл ажиллагааны ус ашиглалт, усны төлбөр, усан орчинд нөлөөлөх байдал, усан орчныг хамгаалах хууль тогтоомж, стандартын мөрдөлт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, ус ашиглалтын байдлыг газар дээр нь тодруулах, баримтжуулах, үнэлэлт, дүгнэлт гаргаж зөвлөмж өгөхөд оршино.

### Ерөнхий мэдээлэл

#### Ус ашиглалт, ашиглалтын усны эх үүсвэр

Төсөл хэрэгжих талбай нь ус зүйн сүлжээгээр Галба-Өөш-Долоодын говийн сав газарт хамаарна. Төслийн үйл ажиллагаанд дараах зориулалтаар ус ашиглана. Үүнд:

- Унд, ахуйн усны хэрэглээ
- Технологийн хэрэглээ (Туршилтын үйлдвэрийн ашигласан сав урвалжийн угаалга, болон цэвэрлэгээ)
- Биологийн нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалга тус тус хамаарна.

Төслийн усны ахуйн хэрэгцээг газрын доорхи усаар буюу гүний худгийн усаар хангадаг. Унд ахуй, технологийн зориулалттай 8 гүний худаг гаргасан ба өнөөгийн байдлаар эдгээрийн 6 худгийг бүрэн хэмжээнд тоолууржуулан ашиглаж байна.

### Аудитын үр дүн

#### Хүснэгт 2.1. Усны нөөц ашиглалт, усны чанар бохирдлын аудитын шинжилгээ

№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо	X/э <sup>2</sup>	Тайлбар
---	------------------	----------------	----------------------	------	------------------	---------

<sup>2</sup> Хяналтын эрэмбэд 1-10 хүртэл оноог оноох ба цар хүрээ багатай арга хэмжээнүүдэд 5 хүртэл оноонуудыг онооно. Арга хэмжээнүүдийн биелэлтийн хувиар нийцэл, үл нийцлийн оноог өгөх ба нэгж тутамд 20%-ийн биелэлт оноогдоно.

				Нийцэл	Үл нийцэл		
В.1.	Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дүгээр хэсэг “Хоногт 100 шоомтрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоомтр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоомтр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг Аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана”, 28 дугаар зүйлийн 18 дугаар хэсэг “Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно”	Ашиглалтын усны эх үүсвэрийн хувьд 2021-2022 онд ус ашиглуулах дүгнэлтийг СГЗ-аар гаргуулж ажилласан. [21]		5	-	5	
В.2.	Усны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад улсын хуулийн этгээд нь тодорхой зориулалт, хугацаа, болзол нөхцөл заасан ус ашиглах зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу ус ашиглах эрхтэй байна”	2021, 2022 онуудад Ус ашиглуулах зөвшөөрлийг Галба-Өөш-Долоодын говийн СГЗ-аас авч Ус ашиглах гэрээг байгуулсан. 2021-2023 оны хугацаанд ашигласан усны зарцуулга, дүгнэлт, зөвшөөрөл, гэрээгээр заагдсан хэмжээг нэгтгэсэн байдлаар хүснэгт 2.2.1-г үзүүлэв: [20, 21, 23]		5	-	5	

№	Шалгуур үзүүлэлт	Тохирол/Нийцэл	Үл тохирол/Үл нийцэл	Оноо		Х/э <sup>2</sup>	Тайлбар
				Нийцэл	Үл нийцэл		
<p><b>Хүснэгт 2.1.1. Уурхайн 2021-2023 оны хугацаанд ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээгээр өгөгдсөн усны хэмжээ, төлбөр ноогдуулсан ба төлөлт хийсэн байдал</b></p>							
Он	Ус ашиглуулах дүгнэлт	Ус ашиглуулах зөвшөөрөл, гэрээ	Ус ашиглалтын тайлант мэдээгээр	Ус ашигласны төлбөр төлөлт	Аудитын шинжилгээний дүн		
